



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,  
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 22 нэрийн, нийт 42,010,774.15 (дөчин хоёр сая арван мянга долоон зуун далан дөрвөн төгрөг арван таван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 29,310,000.00 (хорин есөн сая гурван зуун арван мянган) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Булган аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Ү.Бямбасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 02 дугаар сарын .....-ны өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт

**БУЛГАН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГҮЙ АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуриимтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ /төгрөгөөр/		
							Цаашид ашиглах хугацаа /жилээр/	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Пресс	2012.09.01	1	ш	14,868,250.00	14,868,250.00	5	14,000,000.00	14,000,000.00
2	Хар принтер 3 үйлдэлт	2018.10.16	1	ш	599,900.00	599,900.00	3	270,000.00	270,000.00
3	Процессор делл 2018	2018.09.10	1	ш	1,199,900.00	1,199,900.00	3	300,000.00	300,000.00
4	Хөргөгч	2012.12.26	1	ш	299,900.00	299,900.00	5	300,000.00	300,000.00
5	Хөргүүр төхөөрөм	2016.06.30	1	ш	749,900.00	749,900.00	3	400,000.00	400,000.00
6	Делл процессор	2016.11.14	1	ш	1,299,900.00	1,299,900.00	3	300,000.00	300,000.00
7	Принтер самсунг	2016.12.14	2	ш	289,000.00	578,000.00	1	100,000.00	200,000.00
8	Видео камер	2016.12.31	1	ш	549,990.00	549,990.00	3	400,000.00	400,000.00
9	Сервер зам	2016.12.31	1	ш	275,400.00	275,400.00	3	250,000.00	250,000.00
10	ЖРС хэмжих багаж	2017.01.07	14	ш	427,500.00	5,985,000.00	3	250,000.00	3,500,000.00
11	3 үйлдэлт принтер	2017.09.26	15	ш	350,000.00	5,250,000.00	3	200,000.00	3,000,000.00
12	Санхүүгийн програ	2016.02.28	1	ш	880,000.00	880,000.00	5	700,000.00	700,000.00
13	Prim түмбочка	2012.08.10	1	ш	224,880.00	224,880.00	5	150,000.00	150,000.00
14	Prim ширээ	2012.09.04	1	ш	479,655.00	479,655.00	5	500,000.00	500,000.00
15	Prim Ширээ хурлын	2012.09.04	1	ш	479,655.00	479,655.00	5	700,000.00	700,000.00

16	Архивын сейф	2011.12.01	17	ш	298,000.00	5,066,000.00	3	150,000.00	2,550,000.00
17	Буйдан	2012.09.04	1	ш	688,415.00	688,415.00	3	500,000.00	500,000.00
18	Котьютрийн ширээ	2004.12.20	1	ш	92,584.15	92,584.15	2	50,000.00	50,000.00
19	Сандаг Ригм	2012.08.10	6	ш	238,085.00	1,428,510.00	5	120,000.00	720,000.00
20	Хивс ЭРДЭНЭТ	2012.12.06	1	ш	600,000.00	600,000.00	5	200,000.00	200,000.00
21	Хөшиг механик	2012.12.16	5	ш	44,670.00	223,350.00	3	50,000.00	250,000.00
22	Ширээ жижиг	2012.09.04	1	ш	191,585.00	191,585.00	3	70,000.00	70,000.00
<b>НИЙТ ДҮН</b>						<b>42,010,774.15</b>			<b>29,310,000.00</b>
						(дөчин хоёр сая арван мянган төгрөг долоон зуун далан дөрвөн төгрөг арван таван мөнгө)			(хорин есөн сая төгрөг гурван зуун арван арван мянга)